



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

“Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны эхний хагас жилийн байдлаар удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасныг зөрчиж нийт 52.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил, дутагдал илэрсэнийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны эхний хагас жилийн байдлаар удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Алтангадас/-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;


2.2. Ашиглалтгүй байгаа, анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон үндсэн хөрөнгийг актлах, худалдах асуудлыг судалж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсаны үндсэн дээр эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.3. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийн талаарх саналаа танилцуулж байх;

2.6. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтийг 2019 оны 4 дүгээр сард багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А.АРИУНБОЛД

D:\muraldaanii material\2019 on\2019.03.05 №4\Togtool.docx

0000166

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн
87... дугаар тогтоолын хавсралт



“Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.1, 48.1 дэх заалтад заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал болон холбогдох ажиллагсад	52,733,500.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж, журмын дагуу зохион байгуулж, тогтоосон хугацаанд тайлан гаргаж байх
Зөрчил, дутагдлын нийт дүн				52,733,500.00